



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 7/135

Улаанбаатар хот

Тэтгэмж олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2, Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8 дахь заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 6 дугаар зүйлийн 6.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрх толгойлсон эх, эцэгүүдийн өрхийн орлогыг дэмжих зорилгоор Санхүү, эдийн засгийн хэлтсийн Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч Наранчулууны Нэргүй, Нэгдсэн цехийн Хими хэсгийн Түлшний лаборант Насанбуянгийн Ариунжаргал нарт тус бүр 550,000 (Таван зуун тавин мянга)-н төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

2. Н.Нэргүй, Н.Ариунжаргал нарт тус бүр 550,000 (Таван зуун тавин мянга)-н төгрөгийн тэтгэмжийг холбогдох зардлаас олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-г даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ